



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2014 оны 06 сарын 25 өдөр

Дугаар 253

Улаанбаатар хот

Г

Журам батлах тухай

Г

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.2, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 14.6 дахь заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

- “Хадгаламжийн бичгийг бүртгэх, нийтэд санал болгон арилжих тухай журам”-ыг хавсралтаар баталсугай.
- Энэхүү журам батлагдсантай холбогдуулан өөрийн дүрэм, журамд өөрчлөлт оруулж, зах зээлд байршуулахад шаардлагатай бэлтгэлийг шуурхай ханган ажиллахыг “Монголын Хөрөнгийн бирж” ХК /Д.Ангар/, “ҮЦТТХТ” ХХК /Т.Гандуlam/-д үүрэг болгосугай.
- Журмын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-нд даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН



000231

**ХАДГАЛАМЖИЙН БИЧГИЙГ БҮРТГЭХ,
НИЙТЭД САНАЛ БОЛГОН АРИЛЖИХ ТУХАЙ ЖУРАМ**

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмын зорилго нь Монгол Улсад гаргах хадгаламжийн бичгийг бүртгэх, түүнийг нийтэд санал болгон худалдах, арилжих болон гадаад улсад хадгаламжийн бичиг гаргах Монгол Улсын хуулийн этгээдийн суурь үнэт цаасыг Санхүүгийн зохицуулах хороо /цаашид “Хороо” гэх/ бүртгэхтэй холбоотой харилцааг зохицуулахад оршино.

1.2. Энэхүү журамд хэрэглэсэн нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

1.2.1. “хадгаламжийн бичиг эзэмшигч” гэж үнэт цаасыг өөрийн нэр дээр бүртгүүлсэн, тухайн үнэт цаасыг эзэмших хугацаанд үүсэх үр шимийг хүртэх эрх бүхий этгээдийг;

1.2.2. “хадгаламжийн гэрээ” гэж хадгаламжийн бичиг гаргагч болон суурь үнэт цаас гаргагчийн хооронд хадгаламжийн бичиг гаргах талаар байгуулсан гэрээг;

1.3. Хадгаламжийн бичиг гаргах үйл ажиллагаанд дараах зарчмыг баримтлана:

1.3.1. нэг төрлийн хадгаламжийн бичиг тус бүр нь нэг төрлийн үнэт цаасны хувь тэнцүү эсхүйг гэрчилнэ;

1.3.2. нэг хадгаламжийн бичиг нь нэг болон түүнээс дээш тооны суурь үнэт цаасаар баталгаажиж болно;

1.3.3. хадгаламжийн гэрээнд өөрөөр заагаагүй бол суурь үнэт цаасыг хадгалалтад аваагүй, эсхүл тоо, хэмжээ бүрэн бус байхад хадгаламжийн бичиг гаргахыг хориглоно;

1.3.4. хадгаламжийн бичгийг хадгаламжийн бичиг гаргагчийн холбогдох дансанд байршуулаагүй байхад түүнийг суурь үнэт цаасанд хөрвүүлэхгүй;

1.3.5. хадгаламжийн бичиг нь суурь үнэт цаасанд чөлөөтэй хөрвөх үндсэн нөхцөлтэй байх бөгөөд хадгаламжийн бичгийг бусад худалдахад түүгээр баталгаажсан суурь үнэт цаасны өмчлөх болон түүнтэй холбоотой бусад эрх худалдан авагчид шилжинэ;

1.3.6. хадгаламжийн бичгийг суурь үнэт цаасанд, эсхүл суурь үнэт цаасыг хадгаламжийн бичигт хөрвүүлэх ажиллагаа нь хариу төлбөргүй хэлцэл байна;

1.3.7. хадгаламжийн бичгийг нэмж гаргах, өмчлөгчийн зөвшөөрлөөр өмнө гаргасан үнэт цаасанд суурилан гаргах, эсхүл эдгээрийн аль алинд суурилан холимог хэлбэрээр гаргаж болно.

1.4. Хадгаламжийн бичгийг биет болон биет бус аль ч хэлбэрээр гаргаж болох бөгөөд нэрийн үнэт цаас байна.

1.5. Хадгаламжийн бичиг нь дараах төрөлтэй байна:

1.5.1. Монгол Улсын хадгаламжийн бичиг (цаашид “МУХБ” гэх);

1.5.2. гадаад улсын хадгаламжийн бичиг (цаашид “ГУХБ” гэх).

1.6. Хадгаламжийн бичгийг зөвхөн үнэт цаасны кастодианы үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий хуулийн этгээдээр дамжуулан гаргана.

1.7. Суурь үнэт цаас эзэмшигч болон хадгаламжийн бичиг эзэмшигчид хүрэх мэдээлэл ижил байна.

1.8. ГУХБ гарсан эсэхээс үл хамаарч суурь үнэт цаас гаргагч нь үйл ажиллагаандaa энэхүү журам болон Монгол Улсын хууль тогтоомжийг дагаж мөрдөнө.

1.9. Энэхүү журамд заасан гадаадад гаргах хадгаламжийн бичгийн бүртгэлийн шаардлага нь Монгол Улсад бүртгэлтэй суурь үнэт цаас гаргагчийн хадгаламжийн бичгээс бусад төрлийн үнэт цаасыг гаргах, тэдгээрийг нэмж гаргахад хамаarahгүй болно.

**Хоёр. Гадаад улсын хадгаламжийн бичгийн
суурь үнэт цаасыг бүртгэх**

2.1. Монгол Улсад бүртгэл бүхий хуулийн этгээдийн суурь үнэт цаасанд тулгуурлан гадаад улсад хадгаламжийн бичиг гаргахад тухайн суурь үнэт цаасыг Хороонд бүртгүүлнэ.

2.2. Энэ журмын 2.1 дэх заалт нь зөвхөн нийтэд санал болгон арилжаалагдах үнэт цаасанд хамаарна.

2.3. Монгол Улсад бүртгэл бүхий суурь үнэт цаасыг хадгаламжийн бичиг гаргах эрх бүхий байгууллага нь кастодианы үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөл бүхий этгээдийн хадгалалтад авч номиналь эзэмшигч нь хадгаламжийн бичиг гаргагч өөрөө байна.

2.4. ГУХБ гаргах шийдвэрийг суурь үнэт цаас гаргагчийн хувьцаа эзэмшигчдийн хурал гаргана.

2.5. Энэхүү журмын 2.4-д заасан шийдвэр гарснаас хойш ажлын 5 хоногийн дотор Хороо, Хөрөнгийн бирж болон нийтэд мэдэгдэнэ.

2.6. Суурь үнэт цаас гаргагч Хороонд бүртгүүлснээр хадгаламжийн бичиг гаргах эрх бүхий этгээдээр дамжуулан ГУХБ гаргаж болно.

2.7. ГУХБ гаргах шийдвэрт дараах зүйлийг тусгана:

2.7.1. суурь үнэт цаасны төрөл, тоо, хэмжээ, арилжаалахаар төлөвлөсөн хугацаа;

2.7.2. хадгаламжийн гэрээний төсөл, үндсэн нөхцөл болон бусад шаардлага;

2.7.3. хадгаламжийн бичиг гаргах гадаад улсын үнэт цаасны зах зээлийн талаар дэлгэрэнгүй мэдээлэл.

2.8. Хороо дараах баримт, бичгийг үндэслэн суурь үнэт цаасыг бүртгэнэ:

2.8.1. суурь үнэт цаасыг бүртгүүлэх тухай хүсэлт;

2.8.2. ГУХБ гаргах тухай шийдвэр;

- 2.8.3. суурь үнэт цаасны төрөл, тоо, гаргахаар төлөвлөсөн хугацаа болон холбогдох бусад мэдээлэл;
- 2.8.4. ГУХБ гаргах хуулийн этгээдийн талаарх дэлгэрэнгүй мэдээлэл;
- 2.8.5. суурь үнэт цаасны арилжигдаж буй хөрөнгийн биржээс ГУХБ гаргахад татгалзах зүйлгүй тухай албан тодорхойлолт;
- 2.8.6. хадгаламжийн гэрээний төсөл;
- 2.8.7. хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээний нотариатаар гэрчлүүлсэн хуулбар;
- 2.8.8. зохицуулалтын үйлчилгээний хураамж төлсөн баримт;
- 2.8.9. хадгаламжийн бичгийн өмчлөх эрхийн нэгдсэн бүртгэл, суурь үнэт цаасны кастодианы үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий этгээдтэй байгуулсан гэрээ.

2.9. Хороо бүрдүүлбэр нь бүрэн хүсэлтийг хүлээж авснаас хойш 30 хоногт хянаж шийдвэрлэнэ.

2.10. ГУХБ нь тухайн хадгаламжийн бичгийг арилжих зах зээл, улсыг илэрхийлсэн тухайлсан нэртэй байж болно.

2.11. ГУХБ анхдагч зах зээлд гаргах ажиллагааг дуусгавар болох хүртэл арилжааны явцын талаарх мэдээллийг суурь үнэт цаас гаргагч нь улирал бүрийн эхний долоо хоногт Хороо, Хөрөнгийн бирж болон олон нийтэд мэдээлнэ. Энэ тухай мэдээлэхдээ дараах зүйлсийг анхаарвал зохино. Үүнд:

2.11.1. Үнэт цаасны зах зээлийн тухай хууль болон Хорооны 2013 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн 505 тогтоолоор баталсан “Үнэт цаас гаргагчаас мэдээллийг нийтэд тогтмол хүргэх тухай” журмын дагуу, хугацаанд нь нийтэд ил тод болговол зохих мэдээллийг мэдээлэх бололцоог суурь үнэт цаас гаргагч хангаж ажиллах;

2.11.2. Суурь үнэт цаас гаргагч нь өөрийн цахим хуудсаараа мэдээллийг нийтэд тогтмол хүргэх ба Хөрөнгийн биржийн вэб хуудаст мэдээллийг байршуулна;

2.11.3. Хадгаламжийн бичиг гаргах хөтөлбөрийн хүрээнд хэдэн суурь үнэт цаасыг хадгалалтад авч хөрвүүлсэн талаар мэдээллийг мэдээлнэ.

2.12. Хадгаламжийн бичиг гаргагч нь Монгол Улсад бүртгэлтэй суурь үнэт цаасны номиналь эзэмшигч байх ба Монгол Улсад үйл ажиллагаа явуулах кастодианы тусгай зөвшөөрөл бүхий этгээдэд өөрийн нэр дээр хадгалуулна.

2.13. Тухайн компанийн суурь үнэт цаасны 5 хувьтай тэнцэх хэмжээний хадгаламжийн бичиг эзэмшиж буй тухайгаа болон уг хувь 5 хувиар нэмэгдэх бүрт Хороонд мэдэгдэнэ.

Гурав. Монгол улсын хадгаламжийн бичгийг бүртгэх

3.1. Хороо МУХБ-ийг үнэт цаасны нэгдсэн бүртгэлд бүртгэснээр үнэт цаасны арилжаанд оруулах ба хөрөнгө оруулагчдын эрх, үүрэг, хариуцлага болон холбогдох харилцааг Үнэт цаасны зах зээлийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжоор зохицуулна.

3.2. Монгол улсад бүртгэлтэй үнэт цаасанд суурилсан МУХБ гаргах, эсхүл МУХБ-ийн суурилсан суурь үнэт цаасыг бүртгүүлэн арилжихыг хориглоно.

3.3. МУХБ-ийг дор дурдсан дарааллын дагуу гаргана:

3.3.1. гадаадын суурь үнэт цаас гаргагчаас МУХБ гаргах тухай шийдвэр гаргах;

3.3.2. хадгаламжийн гэрээ байгуулах;

3.3.3. МУХБ-ийг Хороонд бүртгүүлэх;

3.3.4. Монголын Хөрөнгийн бирж, үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий хуулийн этгээдэд бүртгүүлж, анхдагч болон хоёрдогч зах зээлийн арилжааг зохион байгуулах бэлтгэлийг хангах;

3.3.5. МУХБ-ийг нийтэд санал болгон худалдах.

3.4. МУХБ гаргах, худалдах үйл ажиллагаанд Монгол Улсын хууль тогтоомжийг мөрдөнө.

3.5. Хадгаламжийн бичиг гаргагч нь хадгаламжийн бичгээ Хороонд бүртгүүлсний үндсэн дээр нийтэд санал болгон худалдаж болох бөгөөд энэ журам болон Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Хорооны 2014 оны 06 дугаар тогтоолоор баталсан “Үнэт цаасны бүртгэлийн журам”-д заасан холбогдох баримт бичгийг бүрдүүлэн ирүүлнэ.

3.6. МУХБ-ийг дор дурдсан этгээд гаргаж болно:

3.6.1. кастодианы үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий хуулийн этгээд;

3.6.2. андеррайтерийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий хуулийн этгээд;

3.6.3. олон улсын хэмжээнд хадгаламжийн бичиг гаргах эрх бүхий санхүүгийн байгууллага.

3.7. МУХБ-ийн суурь үнэт цаас гаргагч хуулийн этгээд нь өөрийн улсын дагаж мөрдөж буй хууль тогтоомж болон компанийн дүрмийн дагуу МУХБ гаргах тухай шийдвэрийг гаргасан байна.

3.8. МУХБ гаргах тухай шийдвэрт дараах зүйлийг тусгасан байна;

3.8.1. суурь үнэт цаас гаргагчийн нэр, оршин байгаа газар, түүний харьяалах гадаад улсын хуулийн дагуу хуулийн этгээдийнх нь хувьд ялгагдах шинжийг тодорхойлсон бусад мэдээлэл;

3.8.2. суурь үнэт цаасны хэлбэр, төрөл, ангилал;

3.8.3. хадгаламжийн бичиг эзэмшигчийн суурь үнэт цаасаар гэрчлэгдсэн эрх;

3.8.4. тухайн гаргалтын нэг хадгаламжийн бичгээр өмчлөх эрх нь гэрчлэгдэх суурь үнэт цаасны тоо;

3.8.5. эргэлтэд байж болох хадгаламжийн бичгийн дээд хязгаар.

3.9. Хадгаламжийн бичиг гаргагч нь суурь үнэт цаас гаргагчтай хадгаламжийн гэрээ байгуулсны үндсэн дээр хадгаламжийн бичиг гаргана.

3.10. Хадгаламжийн гэрээнд дараах зүйлсийг заавал тусгана:

3.10.1. хадгаламжийн бичгийг арилжаалах нөхцөл;

3.10.2. хадгаламжийн бичиг гаргагч болон хадгаламжийн бичиг эзэмшигч хоорондын эрх, үүрэг, гэрээг зөрчсөнөөс үүсэх хариуцлагын тухай;

3.10.3. өөрийн нэр дээр, гуравдагч этгээдийн ашиг сонирхлын тулд данс нээлгэн бүртгэсэн суурь үнэт цаасны тоо нь арилжаанд байгаа хадгаламжийн бичгийн тоонд нийцсэн байх нөхцлийг хангах талаарх хадгаламжийн бичиг гаргагч байгууллага болон кастодианы үүрэг;

3.10.4. хадгаламжийн бичиг эзэмшигчийн суурь үнэт цаасны тухайд эдлэх эрх, үүрэг, суурь үнэт цаасаар тодорхойлогдох саналыг нь нэгтгэн уламжлах, саналын дүнг танилцуулах журмын тухай, ногдол ашиг болон бусад үр шимиийг хүртэх эрхийг эдлүүлэх, холбогдох ажиллагааг хэрхэн зохион байгуулах журам;

3.10.5. суурь үнэт цаас болон суурь үнэт цаас гаргагчийн талаар нийтэд мэдээлбэл зохих мэдээллийг хууль тогтоомж болон Хорооны 2013 оны 505 дугаар тогтоолоор баталсан “Үнэт цаас гаргагчаас мэдээллийг нийтэд тогтмол хүргэх тухай журам”-ын дагуу тухай бүр сaadгүй гаргаж өгөх талаар суурь үнэт цаас гаргагчийн хүлээх үүрэг;

3.10.6. МУХБ эзэмшигчийн өмнө суурь үнэт цаас гаргагч үүрэг хүлээж байгаа эсэх тухай мэдээлэл;

3.10.7. хадгаламжийн бичиг эзэмшигчийн анхны шаардлагаар хадгаламжийн бичгийг цуцлах, холбогдох суурь үнэт цаасны өмчлөх эрхийн бүртгэлийг гүйцэтгэх, хадгаламжийн бичиг эзэмшигчийн зөвшөөрөлгүйгээр хадгаламжийн бичгийг цуцалж болохгүй тухай;

3.10.8. хадгаламжийн бичиг эзэмшигчийн хүсэлтийн дагуу хадгаламжийн бичгийг холбогдох суурь үнэт цаасанд хөрвүүлэх нехцэл болон хадгаламжийн бичиг эзэмшигчийн эсхүл суурь үнэт цаас өмчлөгчийн зөвшөөрөлгүйгээр тэдгээрийг захиран зарцуулах, бусдад шилжүүлэх болон хөрвүүлэхгүй байх тухай;

3.10.9. Хороо, хөрөнгийн биржид шаардлагатай мэдээллийг сaadгүй гаргаж өгөх үүргийн тухай, уг үүргийг хэрэгжүүлэхэд талууд хэрхэн хамтарч ажиллах тухай;

3.10.10. хадгаламжийн бичиг гаргагчийн зүгээс суурь үнэт цаас болон хадгаламжийн бичгийн бүртгэл, төлбөр, тооцоо, хадгалалтын зохион байгуулалт; Хэрэв суурь үнэт цаас болон хадгаламжийн бичгийн хадгалалтыг эрх бүхий өөр кастодиан байгууллагаар хийлгэх бол энэ харилцааг зохицуулах гэрээ;

3.10.11. суурь үнэт цаасны орлого болон бусад төлбөрийг хадгаламжийн бичиг эзэмшигчид олгох хугацаа;

3.10.12. энэ журмын 3.10.11-т заасан орлого болон бусад төлбөрийг олгоходоо хадгаламжийн бичиг гаргагчийн авах үйлчилгээний шимтгэлийн дээд хязгаар, тийнхүү шимтгэл авах үндэслэл;

3.10.13. суурь үнэт цаасаар гэрчлэгдсэн эрхийг хэрэгжүүлэх зорилгоор хадгаламжийн бичиг эзэмшигчдийн жагсаалтыг гаргах журам, хугацаа;

3.10.14. хадгаламжийн бичиг гаргагч эсхүл кастодиан зэрэг арилжааны төлбөр тооцоо, хадгаламжийн үйл ажиллагаа эрхэлж байгаа этгээдийг өөрчлөх, үйлчилгээг бусдад шилжүүлэх нехцэл, шилжүүлэх нехцлийн тухай;

3.10.15. хадгаламжийн гэрээнд өөрчлөлт оруулах, түүнийг дуусгавар болгох, цуцлахтай холбоотой зохицуулалт;

3.10.16. суурь үнэт цаас болон хадгаламжийн бичиг гаргагч нь хууль тогтоомжийн хүрээнд үйл ажиллагаа явуулах баталгаа;

3.10.17. энэ гэрээнээс үүссэн харилцаанд Монгол Улсын хуулийг хэрэглэх тухай зохицуулалт;

3.11. Хадгаламжийн гэрээ нь тухайн хадгаламжийн бичгийн танилцуулгын салшгүй хэсэг байна.

3.12. МУХБ-ийн танилцуулгад хадгаламжийн бичиг гаргагч болон суурь үнэт цаас гаргагчийн талаарх дор дурдсан мэдээллийг тусгасан байна:

3.12.1. суурь үнэт цаасны талаарх мэдээллийг Хорооны 2014 оны 6 дугаар тогтоолоор баталсан “Үнэт цаасны бүртгэлийн журам”-д заасны дагуу бэлтгэх бөгөөд дараах зүйлсийг нэмж тусгасан байна:

3.12.1.1. суурь үнэт цаасны эрсдлийн шинжилгээ;

3.12.1.2. нэгж хадгаламжийн бичиг болон түүгээр гэрчлэх суурь үнэт цаас хоёрын хөрвөх харьцаа;

3.12.1.3. хадгаламжийн бичгийн гаргаж болох дээд хэмжээ /ширхэгээр/, хадгаламжийн бичгийг тодорхой хугацаатай гаргаж байгаа бол түүний хугацаа;

3.12.1.4. хадгаламжийн бичигт үндэслэн санал өгөх, ногдол ашиг авах, мэдээлэл авах болон хадгаламжийн бичгийг суурь үнэт цаасанд хөрвүүлэх журам;

3.12.1.5. суурь үнэт цаас гаргагчийн хувь нийлүүлсэн болон өөрийн хөрөнгийн хэмжээ, гаргасан үнэт цаасны тоо ширхэг, тэдгээрийн нэрлэсэн үнэ, тухайн суурь үнэт цаасны хяналтын багцыг эзэмшиж байгаа үнэт цаас эзэмшигчийн нэрсийн жагсаалт.

3.12.2. Хадгаламжийн бичиг гаргагчийн тухай мэдээлэл:

3.12.2.1. хадгаламжийн бичиг гаргагчийн оноосон нэр, оршин байгаа газар, хаяг, шуудангийн хаяг, хадгаламжийн бичиг гаргах эрх бүхий тухай мэдээлэл;

3.12.2.2. хадгаламжийн бичиг гаргагчийн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар;

3.12.2.3. хадгаламжийн бичиг гаргагчаас үзүүлэх үйлчилгээний төрөл, хураамжийн хэмжээ;

3.12.2.4. хадгаламжийн бичиг гаргаж байсан туршлага, нотлох баримт;

3.12.2.5. хадгаламжийн бичигт үндэслэн санал өгөх, ногдол ашиг авах, мэдээлэл авах болон хадгаламжийн бичгийг суурь үнэт цаасанд хөрвүүлэх журам.

3.13. Хадгаламжийн бичиг гаргагч нь МУХБ-ийг Хороонд бүртгүүлэх хүсэлт гаргахдаа Хорооы 2014 оны 6 дугаар тогтоолоор баталсан “Үнэт цаасны бүртгэлийн журам”-д зааснаас гадна дор дурдсан бичиг баримтыг ирүүлнэ:

3.13.1. МУХБ-ийг бүртгүүлэх тухай хүсэлт;

3.13.2. МУХБ гаргах тухай суурь үнэт цаас гаргагчийн шийдвэрийн хуулбар;

3.13.3. суурь үнэт цаас гаргагчийн үнэт цаас тухайн гадаад улсын хөрөнгийн бирж, зохицуулагч байгууллагаас МУХБ гаргахад татгалзах зүйлгүй тухай албан мэдэгдэл;

3.13.4. МУХБ-ийн танилцуулга болон хадгаламжийн гэрээний төсөл;

3.13.5. хадгаламжийн бичиг гаргагчийн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар;

3.13.6. Хадгаламжийн бичиг эзэмшигчид үзүүлэх үйлчилгээ, үйлчилгээний хөлсний тухай мэдээлэл;

3.13.7. хэрэв энэхүү журмын 3.6.3-т заасан этгээд МУХБ гаргах гэж байгаа бол гадаад улсад турваас доошгүй удаа хадгаламжийн бичгийн хөтөлбөр амжилттай хэрэгжүүлсэн тухай нотолгоо, танилцуулга;

3.13.8. хүсэлтэд заасан мэдээллийг нотлох бусад нэмэлт баримт, материалууд;

3.13.9. зохицуулалтын үйлчилгээний хураамж төлсөн баримт.

3.14. Хороо бүрдүүлбэр нь бурэн хүсэлтийг хүлээж авснаас хойш 30 хоногт шийдвэрлэнэ.

3.15. Хороо дараах үндэслэлээр бүртгэхээс татгалзаж болно:

3.15.1. тухайн суурь үнэт цаас нь Хороонд бүртгэлтэй болон Монгол Улсын үнэт цаасны зах зээлд арилжаалагдаж байгаа;

- 3.15.2. ирүүлсэн баримт бичиг нь агуулгын хувьд хоорондоо зөрчилтэй, тоон үзүүлэлт нь зөрүүтэй буюу дахин магадлах шаардлагатай;
- 3.15.3. баримт бичгийг хуурамчаар бүрдүүлсэн, эсхүл хуурамч мэдээ, баримт тусгасан нь илэрсэн;
- 3.15.4. хадгаламжийн бичиг гаргагч нь төлбөрийн болон хөрвөх чадваргүй болох нь тогтоогдсон.

Дөрөв. МУХБ-ийг нийтэд санал болгон арилжих

- 4.1. МУХБ болон түүний танилцуулгыг Хороо бүртгэснээр түүнийг нийтэд арилжаалахыг зөвшөөрнө.
- 4.2. Хороо бүртгээгүй МУХБ-ийг нийтэд танилцуулах, арилжаалахыг хориглоно.
- 4.3. Хадгаламжийн бичгийн суурь үнэт цаасыг хадгалалтад аваагүй, эсхүл тоо, хэмжээ нь дутуу байхад хадгаламжийн бичиг гаргахыг хориглоно.
- 4.4. Аливаа төлбөрийн даалгавар, барьцаа, батлан даалт зэрэг үүргийн гүйцэтгэлтэй холбоотой байгаа, уг нөхцөл байдлаас чөлөөлөгдөөгүй суурь үнэт цаасыг ашиглан хадгаламжийн бичиг гаргахыг хориглоно.
- 4.5. Хадгаламжийн гэрээнд заасны дагуу хадгаламжийн бичиг гаргагч нь суурь үнэт цаас гаргагчийн хувьд зуучлагчийн үүрэг гүйцэтгэнэ. Хадгаламжийн бичгийг бусдад худалдахад түүнийг баталгаажуулсан суурь үнэт цаасны өмчлөх эрх худалдан авагчид шилжсэнд тооцно.
- 4.6. МУХБ-ийг Хороонд бүртгүүлэхдээ нийт гаргаж болох дээд хязгаараар бүртгэх бөгөөд уг хязгаарын дотор үнэт цаасыг хадгаламжийн бичигт хөрвүүлэн Монгол улсын үнэт цаасны зах зээлд арилжих, хадгаламжийн бичгийг суурь үнэт цаасанд хөрвүүлэх, хүчингүй болгосон хадгаламжийн бичгийг нөхөн гаргах зэрэгт Хороонд тухай бүр бүртгүүлэхийг шаардахгүй бөгөөд уг ажиллагааг Хөрөнгийн бирж болон үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий хуулийн этгээд, кастодианы шууд хяналтад хэрэгжүүлнэ.
- 4.7. Хороонд бүртгүүлсэн МУХБ-ийг Хөрөнгийн бирж, үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий хуулийн этгээдийн холбогдох бүртгэлд бүртгүүлсний дараа хадгаламжийн бичгийг нийтэд санал болгон худалдана.
- 4.8. МУХБ-ийг анх удаа нийтэд санал болгон худалдах ажиллагаанд Хорооны 2014 оны 6 дугаар тогтоолоор баталсан “Үнэт цаасны бүртгэлийн журам”-ыг баримтлана.
- 4.9. Хадгаламжийн бичиг гаргагчийг суурь үнэт цаас гаргагчтай байгуулсан хадгаламжийн гэрээний хүрээнд түүний даалгавар гүйцэтгэгч гэж үзэх бөгөөд Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд заасан журмыг ханган ажиллана.
- 4.10. Хадгаламжийн бичгийн өмчлөх эрхийн нэгдсэн бүртгэл, хадгалалтын хувьд үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий хуулийн этгээд, эсхүл

кастодианы үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий этгээдэд бүртгүүлэх бөгөөд харин гадаад улсад үндсэн бүртгэл бүхий суурь үнэт цаасыг хадгалуулахыг заавал шаардахгүй. Энэ тохиолдолд хадгаламжийн бичиг гаргагч нь суурь үнэт цаас гаргагчтай хамтран эсхүл дангаар холбогдох эрх бүхий кастодиан байгууллагыг гэрээний үндсэн дээр ажиллуулж болно.

4.11. Хадгаламжийн бичиг болон суурь үнэт цаас хоёрыг чөлөөтэй хөрвүүлэхэд шаардлагатай банк, санхүүгийн байгууллагууд хоорондын зохион байгуулалтын ажлыг хадгаламжийн бичиг гаргагч зохион байгуулах үүрэг хүлээнэ.

4.12. Хадгаламжийн бичиг гаргагч нь түүнийг эзэмшигчдэд олгох мөнгөн төлбөрийг Монгол Улсын мөнгөн тэмдэгт-төгрөгөөр хийнэ. Кастодиан нь уг мөнгөн төлбөрийг хүлээн авснаас хойш 5 хоногийн дотор суурь үнэт цаас гаргагчид шилжүүлнэ.

4.13. Хадгаламжийн бичиг гаргагчаас ирүүлсэн МУХБ гаргах тухай шийдвэрт оруулсан өөрчлөлтийг Хороо хянаж, хүлээн авснаас хойш 20 хоногийн дотор Үнэт цаасны зах зээлийн тухай хууль тогтоомжийг зөрчөөгүй бол бүртгэх буюу эсхүл бүртгэхээс татгалзсан тухай үндэслэл бүхий хариу өгнө. Хороо ирүүлсэн баримт бичигт дурдсан мэдээллийн талаар шалгалт хийх эрхтэй.

4.14. Хадгаламжийн бичиг гаргагч нь энэ журмын 4.6-д заасан хязгаарыг өөрчлөх хүсэлтэй нөхцөлд Хороонд хадгаламжийн бичиг бүртгүүлэх хүсэлтийг энэ журмын дагуу дахин гаргана.

Тав. Хадгаламжийн бичгийг суурь үнэт цаасанд хөрвүүлэх болон арилжааны тайлан гаргах

5.1. Хадгаламжийн бичгийг хэдийд ч суурь үнэт цаасанд хөрвүүлж болох ба хөрвүүлэх ажиллагаа нь хариу төлбөргүй хэлцэл байна.

5.2. Хадгаламжийн бичиг нь суурь үнэт цаасанд чөлөөтэй хөрвөх үндсэн нөхцөлтэй байх бөгөөд хадгаламжийн бичиг гаргагч нь хадгаламжийн бичиг эзэмшигч хүсэлт гаргасан тохиолдолд түүний хүсэлтээр суурь үнэт цаасанд хөрвүүлж, суурь үнэт цаасны өмчлөгчөөр бүртгэх ажиллагааг гүйцэтгэж өгөх үүрэгтэй.

5.3. Энэ журмын 5.2-д заасан хүсэлтийг биелээгүйн улмаас үүссэн хохирлыг хадгаламжийн бичиг гаргагч барагдуулах үүрэгтэй.

5.4. Хадгаламжийг бичгийг хөрвүүлэхдээ дараах дарааллыг баримталж холбогдох ажиллагааг гүйцэтгэнэ:

5.4.1. хадгаламжийн бичиг эзэмшигч хадгаламжийн бичгийг хадгаламжийн бичиг гаргагч эрх бүхий байгууллагад шилжүүлнэ;

5.4.2. хадгаламжийн бичиг гаргагч нь хадгаламжийн бичгийг хүлээн авсан даруйд суурь үнэт цаасыг тухайн хадгаламжийн бичиг эзэмшиж байсан хөрөнгө оруулагчийн дансанд хийнэ;

5.4.3. хадгаламжийн гэрээнд заасан хадгаламжийн бичгийг хөрвүүлэхдээ түүнтэй холбоотой аливаа төлбөр, татвар төлж барагдуулах зэрэг нөхцлийг бүрэн хангагдсан байх явдлыг хадгаламжийн бичиг гаргагч хариуцна;

5.4.4. хадгаламжийн бичгийг суурь үнэт цаасанд хөрвүүлж хөрөнгө оруулагчийн дансанд шилжүүлснээр суурь үнэт цаасны эзэмших эрх хадгаламжийн бичиг гаргагчаас хөрөнгө оруулагч руу шилжинэ.

5.5. Хадгаламжийн бичгийг хөрвүүлэх болон нийт хадгаламжийн бичгийг эргүүлэн татах ажиллагааны журмыг хадгаламжийн гэрээгээр зохицуулна.

5.6. Нийт хадгаламжийн бичгийг эргүүлэн татах тохиолдолд энэ тухай Хороо, Монголын Хөрөнгийн бирж, төвлөрсөн хадгаламжийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий этгээд, кастодианы үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий этгээд болон нийтэд 30-аас доошгүй хоногийн өмнө мэдэгдэх үүрэгтэй.

5.7. Хадгаламжийн бичиг гаргагч нь хадгаламжийн бичгийн арилжааны талаарх тайлан, хөрвүүлсэн болон нэмж гаргасан хадгаламжийн бичгийн талаарх хагас жилийн тайланг тухайн жилийн 7 дугаар сард, жилийн тайланг дараа оны эхний сард багтаан Хороо, Хөрөнгийн биржид хүргүүлж, нийтэд мэдээлэх үүрэг хүлээнэ.

Зургаа. Хадгаламжийн бичиг гаргах ажиллагаанд оролцогчдын эрх, үүрэг

6.1. Хадгаламжийн бичиг эзэмшигч нь дараах эрх, үүрэгтэй байна:

6.1.1. хадгаламжийн бичиг гаргагчаас түүний талаар болон суурь үнэт цаасны талаарх мэдээллийг монгол хэлээр хүлээн авах;

6.1.2. өөрийн эзэмшиж буй хадгаламжийн бичгийн хувь хэмжээгээр суурь үнэт цаасанд ногдох саналын эрхийг эдлэх, саналаа хадгаламжийн бичиг гаргагчаар дамжуулан өгөх, үр дүнтэй нь танилцах;

6.1.3. өөрийн эзэмшил дэх хадгаламжийн бичигт ногдох ногдол ашиг, хүү зэрэг үр шимиийг хүлээн авах, түүнийг захиран зарцуулах;

6.1.4. хадгаламжийн гэрээнд заасан нөхцөл, журмын хүрээнд өөрийн эзэмшил дэх хадгаламжийн бичгээ суурь үнэт цаасанд хөрвүүлэх;

6.1.5. хадгаламжийн бичиг худалдах, худалдан авах шийдвэр гаргах;

6.1.6. хадгаламжийн бичиг эзэмшихтэй холбоотой хадгаламжийн бичиг гаргагчаас үзүүлсэн үйлчилгээний хөлсийг тухай бүр хадгаламжийн гэрээнд заасан хувь хэмжээгээр төлөх үүрэг хүлээнэ.

6.2. Хадгаламжийн бичиг гаргагч нь дараах эрх, үүрэгтэй байна:

6.2.1. ГУХБ гаргагч нь кастодианы үүргийг хүлээж байгаа бол Хорооноос тогтоосон “Кастодианы үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн болон үйл ажиллагааны журам”-ын дагуу үйл ажиллагаа явуулах;

6.2.2. хадгаламжийн гэрээний хэрэгжилтийг хангахыг суурь үнэт цаас гаргагчаас шаардах;

6.2.3. суурь үнэт цаас гаргагч болон суурь үнэт цаас эзэмшигчээс холбогдох суурь үнэт цаасыг хадгаламжийн бичиг гаргагчийн кастодиан дахь хадгалалтад оруулах үүргээ биелүүлээгүй тохиолдолд хадгаламжийн бичиг гаргахаас татгалзах, эсхүл хүчингүй болгох;

6.2.4. хадгаламжийн гэрээнд заасан харьцаагаар гаргасан хадгаламжийн бичгийг баталгаажуулж буй холбогдох суурь үнэт цаасыг өөрийн эсхүл гэрээний үндсэн дээр үүрэг хүлээлгэсэн кастодианы хадгалалтад байлгах;

6.2.5. хадгаламжийн бичиг эзэмшигч нь өөрийн эзэмшил дэх хадгаламжийн бичгээ суурь үнэт цаасанд хөрвүүлэн эзэмшсэнээс бусад тохиолдолд арилжаанд байгаа хадгаламжийн бичгийн тоонд тохирох суурь үнэт цаасыг хадгалалтдаа байлгах;

6.2.6. хадгаламжийн гэрээнд заасны дагуу холбогдох үйлчилгээний хөлсийг суурь үнэт цаас гаргагч болон хадгаламжийн бичиг эзэмшигчээс авах, түүнийг нэхэмжлэх;

6.2.7. суурь үнэт цаас гаргагчаас холбогдох мэдээлэл ирүүлэхийг шаардах, ирсэн мэдээллийг орчуулан зохих журмын дагуу хадгаламжийн бичиг эзэмшигчдэд хүргэх;

6.2.8. Монгол улсын хууль, тогтоомж, холбогдох журам болон хадгаламжийн гэрээнд заасны дагуу хадгаламжийн бичиг гаргагч нь хадгаламжийн бичиг эзэмшигчийн саналын эрхийг төлөөлж болно.

6.2.9. суурь үнэт цаас гаргагчаас аливаа ногдол ашиг хуваарилсан тохиолдолд түүнийг тухайн орны мөнгөн тэмдэгтэд хөрвүүлэн олгох ажлыг гэрээний дагуу гүйцэтгэх;

6.2.10. хадгаламжийн бичиг эзэмшигчийн ногдол ашиг авах болон бусад эрхийг шуурхай бөгөөд шударгаар суурь үнэт цаас гаргагчид уламжлах, эрхийн хэрэгжилтийг хангаж ажиллах;

6.2.11. нийт гаргасан хадгаламжийн бичгийн бүртгэлийг хетлөх, тогтоосон хязгаарын хүрээнд хадгаламжийн бичгийг нэмж гаргах, хадгаламжийн бичгийг хүчингүй болгон суурь үнэт цаасанд хөрвүүлэх.

6.3. Суурь үнэт цаас гаргагч нь дараах эрх, үүрэгтэй байна:

6.3.1. гадаад улсад хадгаламжийн бичиг гаргах суурь үнэт цаас гаргагч хадгаламжийн гэрээнд заасны дагуу суурь үнэт цаасыг тухай бүр хадгаламжийн бичиг гаргагчийн кастодианы хадгалалтад шилжүүлэх;

6.3.2. хадгаламжийн бичиг гаргах ажиллагаа, түүний арилжааны талаар болон хадгаламжийн бичиг эзэмшигчдийн бүртгэлийн талаар хадгаламжийн бичиг гаргагчаас мэдээлэл авах;

6.3.3. холбогдох мэдээллийг тухай бүр хадгаламжийн бичиг гаргагчид шуурхай хүргэх, хүргэсэн мэдээллийг зохих журмын дагуу гадаадад нийтэд мэдээлэх ажиллагаанд хяналт тавих;

6.3.4. хадгаламжийн бичгийг өөрийн эзэмшлийн суурь үнэт цаасанд тулгуурлан анхдагч зах зээлд гаргасан бол холбогдох хадгаламжийн бичгийг бусдад худалдсаны орлогыг өөрийн дансанд шилжүүлэн авах, холбогдох суурь үнэт цаасны өмчлөх эрхийг эрх бүхий этгээдэд шилжүүлэх;

6.3.5. хадгаламжийн бичиг гаргагчаас нийт гаргасан хадгаламжийн бичиг эзэмшигчдээс ирүүлсэн саналыг нэгтгэн ирүүлснийг зохих журмын дагуу шалгах, зөвшөөрөх, холбогдох санал хураалтад хамруулах, үр дүнг хариу мэдэгдэх.

6.4. Хадгаламжийн бичгийг өмнө гаргасан үнэт цаасанд тулгуурлан гаргаж байгаа тохиолдолд энэ журмын 6.3.1, 6.3.2, 6.3.5-д заасан үүргийг тухайн суурь үнэт цаасыг эзэмшиж байгаа этгээд хүлээнэ.

Долоо. Бусад

7.1. Хадгаламжийн бичиг гаргагч, суурь үнэт цаасыг хадгалж байгаа кастодиан төлбөрийн чадваргүй болсон, төлбөрийн чадваргүй болох ноцтой нөхцөл байдал үүссэн тохиодолд энэ тухай Хороонд мэдэгдэх бөгөөд холбогдох үйлчилгээ үзүүлэх гэрээний эрхийг эрх бүхий өөр байгууллагад шилжүүлэх арга хэмжээ авна.

7.2. Хадгаламжийн бичиг гаргагч, түүний кастодианд хадгалагдаж байгаа хадгаламжийн бичиг, суурь үнэт цаас, тэдгээрийн төлбөр, ногдол ашиг, ногдол хувь зэрэг мэнгөн хөрөнгө нь уг этгээдийн хөрөнгийн эсрэг гарсан аливаа нэхэмжлэл, үүргийн гүйцэтгэлд хамаарахгүй.

7.3. Хадгаламжийн бичиг гаргагч, түүний кастодиан нь төлбөрийн чадваргүй болсон, дампуурсан, онцгой дэглэм тогтоогдсон, эрх хүлээн авагч томилогдсон тохиолдолд энэхүү журмын 7.1-т заасны дагуу хөрөнгийг эрх бүхий этгээдэд шилжүүлэх арга хэмжээ авна.

7.4. Энэхүү журмаар тогтоосон хэм хэмжээг зөрчсөн этгээдэд Үнэт цаасны зах зээлийн тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

---Оо---